



**ХЭНТИЙ АЙМГИЙН
БАТШИРЭЭТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 12 сарын 26 өдөр

Дугаар А/177

Эг

Газар эзэмших эрх шилжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Газрын тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.4 дэх заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Батширээт сумын Норовлин багийн нутаг дэвсгэр Тоонотын 3-328 тоот хаягт байрлах Соёлын төвийн (9076212) эзэмшил дэх 2316002146 нэгж талбарын дугаартай төрийн үйлчилгээний зориулалттай 9620м² газраас сумын Засаг даргын Тамгын газарт (9076549) 5220м² газрыг шилжүүлэн эзэмшүүлсүгэй.

2. Газар эзэмших гэрээнд тусгагдсан зориулалт, нөхцөлийн дагуу газраа эзэмшин, гэрээний биелэлтийг жил бүр дүгнүүлж байхыг газар эзэмших эрхийн гэрчилгээг шилжүүлэн авсан Засаг даргын Тамгын газрын дарга (Б.Эрдэнэчимэг)-т үүрэг болгосугай.

3. Газар эзэмших эрхийн гэрчилгээ олгож, гэрээ байгуулан, гэрээний биелэлтэд байнгын хяналт тавьж ажиллахыг Газрын даамал (Д.Батчимэг)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Б.АЛТАНГЭРЭЛ

232401355